



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 21 өдөр

Дугаар A/633

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.17, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2017 оны А/452 дугаар захирамжаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 4.1, 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, Сумдын Засаг дарга түүний Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Л.Доржбат (Засаг даргын Тамгын газрын даргын албан ўргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Н.Эрдэнэ-Очир (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Г.Энхтайван (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Л.Баярсайхан (Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Н.Түвшинжаргал (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Э.Одончимэг (Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Ж.Уянга (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Х.Мөнхсаруул (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Н.Дэлгэрмаа (Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн)

Л.Мягмармядаг (Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн)

Г.Оюунтунгалаг (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Д.Даариймаа (Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)

2. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, Сумдын Засаг дарга түүний Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ

хийж, үр дүнг үнэлэх удирдамж, аргачлалыг боловсруулан баталж, ажлын хэсгийг удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг ажлын хэсэг (Л.Доржбат) -т үүрэг болгосугай.

3. Сум, агентлагуудын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, хийж үнэлэх ажлыг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн удирдамж аргачлалын дагуу чанартай зохион байгуулж, дүнг нэгтгэн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэг (Л.Доржбат), (Д.Даариймаа) нарт даалгасугай.



ЗАСАГ ДАРГА
2023 оны 12 дүгээр сарын

БАТЛАВ
Ц.МОНХБАТ
2023 оны 12 дүгээр сарын

УДИРДАМЖ

2023 оны дүгээр сарын

Мандалговь хот

Сумдын засаг дарга, түүний Тамгын газрын 2023 оны үйл ажиллагаанд
хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үнэлэх тухай

Зорилго: Аймаг, сумын Засаг даргын Тамгын газраас боловсруулан баталсан бодлогын баримт бичиг түүний зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн эсэхэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэх, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, харилцан туршлага судлах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд оршино.

Хамрах хүрээ: Сумдын Засаг даргын Тамгын газар

Хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөс 2024 оны 01 сарын 15-ны өдрийг дуустал

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн: Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг

НЭГ:ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЧИГЛЭЛ

1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ:

- 1.1. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
- 1.2. Сумын эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт

2. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ:

- 2.1. Аймгийн Засаг даргын сумын Засаг даргатай байгуулсан гэрээний хавсралт төлөвлөгөөний хэрэгжилт
- 2.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт /Сумын Засаг даргын Тамгын газар/
- 2.3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт /Сумын Засаг даргын Тамгын газар/
- 2.4. Байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгжилт

3. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ:

- 3.1. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээ
- 3.2. Шилэн дансны хөтлөлт, ОНХСангийн хэрэгжилт
- 3.3 Хөндлөнгийн үнэлгээ /Аймгийн Засаг даргын Тамгын газар, холбогдох хэлтэс, агентлагууд/

4. Тухайн жилд хийсэн онцлох ажлын үнэлгээ

4.1. Аймгийн Засаг даргатай байгуулсан 2023 онд хамтран ажиллах гэрээний 3-т заасан сумын Засаг даргын хүлээх үүргийн биелэлт, тухайн жилд зохион байгуулсан шинэлэг ажил

ХОЁР: ҮНЭЛГЭЭ ӨГӨХ АРГАЧЛАЛ

Үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журам, аймгийн Засаг даргын 2017 оны А/452 дугаар захирамжаар баталсан журмуудыг баримтална.

Шалгуур үзүүлэлт тус бүр дээр авсан оноог хувьд шилжүүлэн үнэлгээний хувийг гаргана.

Ерөнхий үнэлгээг гаргахдаа 1, 2, 3, 4-р хэсгийн үнэлгээний дундаж хувиар тооцож гаргана.

ГУРАВ: БУСАД

Удирдамжийн 1,2,3 дугаар хэсгийн үзүүлэлтийг холбогдох хэлтэс, агентлагуудаас сумын 2023 оны ажлын явцын болон жилийн эцсийн тайлан, нотлох баримтад үндэслэн үнэлгээг аргачлалын дагуу өгнө.

Сумдын Засаг дарга нар удирдамжийн 4 дүгээр хэсгийн үзүүлэлтийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тайлангаа РР бэлтгэн ажлын хэсгийн өмнө 20 минутад баатааж танилцуулна. /Ажлын хэсэг үнэлгээний хуудсаар оноог өгнө/ Асуулт хариулт /10 мин/.

Удирдамжид тусгагдсан үзүүлэлтийг ажлын хэсгийн бүрэлдэхүүн дүгнэж дуусган, сумдын 2023 оны үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээг нэгтгэн, Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн журмын дагуу 1, 2, 3 дугаар байр эзлүүлнэ.

БАТЛАВ
 ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ДАРГЫН
 АЛБАН ҮҮРГИЙР ТУР ОРЛОН
 ГҮЙЦЭТГЭГЧ  Л.ДОРЖБАТ
 2023 оны 12 дугаар сарын 27

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮЗҮҮЛЭЛТ, ТАЙЛАН ИРҮҮЛЭХ ХУВААРЬ

№	Үнэлэх үзүүлэлт		Үнэлгээ өгөх хэлтэс	Тайлан ирүүлэх хугацаа	Ирүүлэх баримт бичиг
Нэг. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ					
1	1.1.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	1.1.1.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	XШҮХ	2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор XШҮХ-т ирүүлэх	2023 оны төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт, сумын ИТХ-ын тогтоол
2	1.2.Сумын эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт	1.2.1. Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилт	XШҮХ	2023 оны 12 дугаар сарын 15-ны дотор XШҮХ-т ирүүлэх	Тайлан
Хоёр: Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ:					
1	2.1.Аймгийн Засаг даргын сумын Засаг даргатай байгуулсан гэрээний хавсралт төлөвлөгөөний хэрэгжилт	2.1.1.Гэрээний хавсралт төлөвлөгөөний хэрэгжилт	TЗҮХ НБХ СТСХ ХБТХОХ ХЭЗХ	2023 оны 12 дугаар сарын 01-ны дотор ТЗҮХ-д	Төлөвлөгөөний хэрэгжилт
2	2.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт /Сумын ЗДТГ/	2.2.1.Байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	XШҮХ	2023 оны 12 дугаар сарын 10-ны дотор XШҮХ-д	Төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт
		2.2.2.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн эсэх	XШҮХ	2023 оны 12 дугаар сарын 10-ны дотор XШҮХ-д	Хурлын тэмдэглэл

3	2.3.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хетэлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт	2.3.1.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хетэлбөртэй эсэх	ТЗУХ	2023 оны 12 дугаар сарын 10-ны дотор ТЗУХ-д	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хетэлбөр, хетэлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт
		2.3.2.Төрийн албан хаагчийн сургалтын хетэлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт			
		2.3.3.Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хетэлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт			
4	2.4.Байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгжилт	2.4.1.ХШҮХ-ээс өгсөн зөвлөмжийн хэрэгжилт /2022 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлгээд өгсөн зөвлөмж/	XШҮХ	2023 оны 11 дугаар сарын 10-ны дотор ХШҮХ-д ирүүлэх	Зөвлөмжийн хэрэгжилт
		2.4.2.Багийн Засаг дарга нарын үйл ажиллагаа	Статистикийн хэлтэс	-	Статистикийн хэлтсийн үнэлгээг шууд хэрэглэнэ.
		2.4.3.Батлан хамгаалах үйл ажиллагааны хэрэгжилт	ЦШ	12 сарын 15-ны дотор ЦШ-д ирүүлэх	Цэргийн штабаас өгсөн үнэлгээг хэрэглэнэ.
		2.4.4.Аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт	ХБТХОХ	12 сарын 15-ны дотор ХБТХОХ-т ирүүлэх	2023 оны тэргүүлэх чиглэл батлах тухай А/242 тоот захирамжийн хэрэгжилт
		2.4.5.Төрийн аудитын дүгнэлт зөвлөмжийн хэрэгжилт	СТСХ	12 сарын 15-ны дотор СТСХ-т ирүүлэх	Техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл явуулах тухай А/107 тоот захирамжийн хэрэгжилт
		2.4.6.Дотоод хяналтын зөвлөмжийн хэрэгжилт		-	СТСХ-ийн үнэлгээг хэрэглэнэ.
		2.4.7.Аймгаас зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээнд хамрагдсан байдал	НБХ	-	СТСХ-ийн дотоод хяналтаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилт
Гурав: Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ					
1	3.1.Мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт, үр дүн	3.1.1.Мэдээллийн хүртээмжтэй байдлын үнэлгээ	ТЗУХ	2023 оны 12 дугаар сарын 10-ны дотор ТЗУХ-д	98 шалгуур үзүүлэлтийг сайтад байршуулсан бол холбоос линкийг нөтлож баримтын хамт
		3.1.2.Мэдээллийг хугацаандаа нийтэлсэн байдлын үнэлгээ			
		3.1.3.Мэдээллийн бүрэн бүтэн байдлын үнэлгээ			
		3.1.4.Мэдээллийн эх сурвалжийн үнэлгээ			

	3.2. Шилэн дансны хөтлөлт, ОНХСангийн хэрэгжилт	3.2.1.Шилэн дансны хэрэгжилт	СХДАА	-	Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үнэлгээг шууд хэрэглэнэ.
2		3.2.2.ОНХСангийн хэрэгжилт	ХБТХОХ	Сумын ОНХСангийн санхүүжилт, гүйцэтгэлийн баримт, тайланг 12 сарын 5-ны дотор ХБТХОХ-т ирүүлэх	ХБТХОХэлтсийн үнэлгээг шууд хэрэглэнэ.
3	3.3. Хөндлөнгийн үнэлгээ	3.3.1Сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааг дээд шатны байгууллагаар үнэлүүлэх	Аймгийн удирдлагууд, ЗДТГ-ын хэлтсүүд, БШУГ, ЭМГ, СҮГ, УБХ, ТХ, НДХ, ХХҮГ, МЭГ, ЦГ, ГХБХБГ	-	Санал асуулгыг ХШҮХ-ээс зохион байгуулна.

Дөрөв: Тухайн жилд хийсэн онцлох ажлын үнэлгээ

	4.1. Аймгийн Засаг даргатай 2023 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 3-т заасан үүргийн биелэлт, тухайн жилд зохион байгуулсан шинэлэг ажил	4.1.1.Сум байгууллага бүр хог хаягдлаа ангилан ялгах ажилд санаачилгатай ажиллах 4.1.2.“Боловсролын чанар хүртээмжийг дэмжих жил”-ийн ажлын төлөвлөгөө боловсруулан үр дүнтэй ажлуудыг зохион байгуулах 4.1.3.Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх талаар төлөвлөгөө боловсруулж ажиллах 4.1.4.e-mongolia системийг иргэдээд сурталчлах зэрэг төрийн үйлчилгээг цахимжуулах чиглэлээр төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангаж ажиллах 4.1.5.Байгууллагын соёлыг нэвтрүүлэх талаар тодорхой ажлуудыг зохион байгуулж ажиллах 4.1.6.Гадаадын хөрөнгө оруулалтаар төсөл хөтөлбөр, санхүүжүүлэгч байгууллагууд (Элчин сайдын яамд, Олон улсын байгууллагууд)-д нэг болон түүнээс дээш тооны төсөл бичиж хүргүүлэх	ЗДТГ-ын дарга хэлтсийн дарга нар	Тусгай хөтөлбөр, хуваарийн дагуу	Мэдээлэл бэлтгэн оролцоно. /Мэдээллийг 20 минутад багтаан сумын Засаг дарга танилцуулах бөгөөд мэдээлэл бэлтгэсэн байдал, илтгэх чадварыг үнэлнэ/
4					

		<p>4.1.7.Тухайн байгууллагын албан ёсны фейсбүүк хуудсыг идэвхжүүлэх, аймаг орон нутгийн мэдээллийг тогтмол оруулж хэвших</p> <p>4.1.8.Ид шидтэй өрөө байгуулж менежмент хийх</p> <p>4.1.9.ISO стандартыг сүмдад нэвтрүүлэх</p> <p>4.1.10.Сумын төвийн гэрэлтүүлэг, камержуулалт</p> <p>4.1.11.Олон нийт рүү чиглэсэн, бусдад туршлага болохуйц 3 ажлыг танилцуулах</p>		
--	--	---	--	--

БАТЛАВ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *Л.ДОРЖБАТ*
2023 оны 12 дугаар сарын 27

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ҮНЭЛГЭЭ ӨГӨХ АРГАЧЛАЛ

№	Үнэлэх үзүүлэлт	Үнэлгээ өгөх аргачлал	Өгвөл зохих оноо	Үнэлгээ өгөх хэлтэс	Хэлтсүүдийн үнэлгээ ирүүлэх хугацаа	Үнэлгээний мэдээллийн эх сурвалж
---	-----------------	-----------------------	------------------	---------------------	-------------------------------------	----------------------------------

Нэг. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ

1	1.1.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	1.1.1.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	Сумын ИТХ-ын үнэлгээ бодитой эсэхэд анализ хийж, үнэлгээг баталгаажуулна. Хэрэгжилтийн дундаж хувийг оноонд шилжүүлнэ.	10	ХШҮХ	-	2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт, сумын ИТХ-ын тогтоол
2	1.2.Сумын эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт	1.2.1. Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилт	Сумын үзүүлэлтийн дундаж хувийг оноонд шилжүүлнэ.	10	ХШҮХ	-	Тайлан, холбогдох хэлтэс, агентлагийн статистик мэдээлэл
Дүн			20				

Хоёр: Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ

1	2.1.Аймгийн Засаг даргын сумын Засаг даргатай байгуулсан гэрээний хавсралт төлөвлөгөөний хэрэгжилт	2.1.1.Гэрээний хавсралт төлөвлөгөөний хэрэгжилт	Аймгийн Засаг даргын Тамгын хэлтсүүдийн үнэлгээний хувийг шилжүүлнэ.	10	ТЗУХ НБХ СТСХ ХБТХОХ ХЭЗХ	2023 оны 12 дугаар сарын 05-ны дотор ТЗУХ-д, 12 дугаар сарын 15-ны дотор нэгтгэн дүнг ХШҮХ-д ирүүлэх	Тайлан, Хэлтсүүдийн өгсөн үнэлгээний нэгтгэл
2	2.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний	2.2.1.Байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж	9	ХШҮХ	2023 оны 12 дугаар сарын 10-ны дотор ХШҮХ-д ирүүлэх	Тайлан

	хэрэгжилт /Сумын ЗДТГ/		хувийг оноонд шилжүүлнэ.				
		2.2.2.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн эсэх	Хэлэлцүүлсэн бол -1 оноо, хэлэлцүүлээгүй бол – 0 оноо	1	XШҮХ	2023 оны 12 дугаар сарын 10-ны дотор ХШҮХ-д ирүүлэх	Хурлын тэмдэглэл
3	2.3.Терийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	2.3.1.Терийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөртэй эсэх	Хөтөлбөртэй бол-2 хөтөлбөргүй бол-0	2	ТЗУХ	2023 оны 12 дугаар сарын 10-ны дотор ТЗУХ-д, 12 дугаар 25-ны дотор ХШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх	Тайлан
		2.3.2.Терийн албан хаагчийн сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт	Төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж хувийг оноонд шилжүүлнэ.	8			
		2.3.3.Терийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилт					
4	2.4.Байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгжилт	2.4.1.XШҮХ-ээс өгсөн зөвлөмжийн хэрэгжилт /2022 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлээд өгсөн зөвлөмж/ 10 оноо	Зөвлөмжийн хэрэгжилтийн дундаж хувийг оноонд шилжүүлнэ. Хугацаандаа ирүүлсэн- 2 оноо, хугацаа хозорч ирсэн-1 оноо, огт ирүүлээгүй -0 оноо	8 2	ХШҮХ	2023 оны 11 дугаар сарын 10-ны дотор ХШҮХ-д ирүүлэх	Тайлан
		2.4.2.Багийн Засаг дарга нарын үйл ажиллагаа	Статистикийн хэлтсээс өгсөн үнэлгээг шууд хэрэглэнэ.	5			
		2.4.3.Батлан хамгаалах үйл ажиллагааны хэрэгжилт	Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувийг оноонд шилжүүлнэ Цэргийн тоо бүртгэлийн хэрэгжилтийн хувийг оноонд шилжүүлнэ.	5 5	Цэргийн штаб	2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор ХШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх 12 сарын 25-ны дотор ХШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх	Статистик мэдээ Тайлан

			Цэрэг татлагад хамрагдсан гүйцэтгэлийн хувийг оноонд шилжүүлнэ.	5			
			Орон нутгийн хамгаалалтын тодотгол, хуулийн хэрэгжилтийн хувийг оноонд шилжүүлнэ.	5			
		2.4.4.Аймгийн Засаг даргын 2023 захирамжийн хэрэгжилт	2023 оны тэргүүлэх чиглэл батлах тухай А/242 тоот захирамжийн хэрэгжилтийн хувийг оноонд шилжүүлнэ.	5	ХБТХОХ	2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор ХШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх	Тайлан
			Техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл явуулах тухай А/107 тоот захирамжийн хэрэгжилтийн хувийг оноонд шилжүүлнэ.	5	СТСХ	2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор ХШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх	Тайлан
		2.4.5.Төрийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт	Төрийн аудитын дүгнэлт зөвлөмжийн хэрэгжилтийн хувийг оноонд шилжүүлнэ.	10	СТСХ	12 сарын 25-ны дотор ХШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх	Зөвлөмж, тайлан
		2.4.6.Дотоод хяналтын зөвлөмжийн хэрэгжилт	Дотоод хяналтын зөвлөмжийн хэрэгжилтийн хувийг оноонд шилжүүлнэ.	10			
		2.4.7.Аймгаас зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээнд хамрагдсан байдал /Бага олимп Уяхан замбуутивийн наран ХБИ баруун бүсийн чуулган/	Хамрагдалтын дундаж хувийг оноонд шилжүүлнэ.	10	НБХ	12 сарын 25-ны дотор ХШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх	Үнэлгээний хуудас
		Дүн		115			

Гурав: Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ							
1	3.1.Мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт, үр дүн /ТЗУХ/	3.1.1.Мэдээллийн хүртээмжтэй байдлын үнэлгээ	Цахим хуудсанд байршсан бол 15, байршуулаагүй бол-0 Мэдээллийн самбарт байршуулсан бол-10 байршуулаагүй бол-0 Бусад мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтэлсэн бол-5, нийтлээгүй бол -0	30	ТЗУХ	2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор ХШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх	Цахим хуудас Мэдээллийн самбар
	3.1.2.Мэдээллийг хугацаандаа нийтэлсэн байдлын үнэлгээ	Хугацаандаа нийтлэгдсэн бол -30, хугацаа хоцроож мэдээлсэн, шинэчилсэн бол -10, нээлттэй мэдээллийг нийтлээгүй бол -0	30	ТЗУХ	2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор ХШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх	Цахим хуудас Мэдээллийн самбар	
	3.1.3.Мэдээллийн бүрэн бүтэн байдлын үнэлгээ	Нээлттэй мэдээллийг бүрэн гүйцэд мэдээлсэн бол -30 оноо, дутуу нийтэлсэн бол -15 оноо огт мэдээлээгүй бол -0	30	ТЗУХ	2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор ХШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх	Цахим хуудас	
	3.1.4.Мэдээллийн сурвалж	ЭХ нээлттэй мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах эрх бүхий ажилтны харьяалах нэгжийн нэр, албан тушаал, нэр болон холбоо барих мэдээллийг нийтэлсэн бол ХАНГАЛТТАЙ буюу 30 оноо, мэдээллийн аль нэгийг нийтлээгүй бол ДУТУУ буюу 10 оноо, мэдээллийг нийтлээгүй бол ХАНГАЛТГҮЙ буюу 0 оноо.	30	ТЗУХ	2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор ХШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх	Цахим хуудас	

2	3.2. Шилэн дансны хөтлөлт, ОНХСангийн хэрэгжилт	3.2.1.Шилэн дансны хэрэгжилт	Шилэн дансанд мэдээллийг 100 хувь байршуулсан бол-20 оноо, 90-99 хувь -10 оноо, 80-89 хувь -5 оноо, 79 -оос доош хувь бол -0 оноо	20	СХДАА	2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор ХШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх	Shilendans.gov.mn
	3.2.2.ОНХСангийн хэрэгжилт		ОНХСангийн үнэлгээний дундаж хувийг оноонд шилжүүлнэ.	10	ХБТХОХ	2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор ХШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх	тайлан
3	3.3. Хөндлөнгийн үнэлгээ	3.3.1.Сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааг дээд шатны байгууллагаар үнэлүүлэх	Үнэлгээний хуудсаар үнэлгээ авч, дундаж оноогоор үнэлгээ гарана.	10	Аймгийн удирдлагууд, ЗДТГ-ын хэлтсүүд, БШУГ, ЭМГ, СУГ, УБХ, ТХ, НДХ, ХХҮГ, МЭГ, ЦГ, ГХБХБГ	2023 оны 12 дугаар сарын 15-ны дотор	Үнэлгээний хуудас
4	Дүн			160			

Дөрөв. Тухайн жилд хийсэн онцлох ажлын үнэлгээ

1	4.1. Аймгийн Засаг даргатай 2023 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлт, шинэлэг ажил	4.1.1.Гэрээний үүргийн биелэлт /10 шалгуур үзүүлэлтийн /	Гэрээний үүргийн биелэлтийг ажлын хэсгийн үнэлгээний дундаж оноо	50	ЗДТГ-ын дарга, хэлтсийн дарга нар	Тусгай хөтөлбөр, хуваарийн дагуу	Бэлтгэсэн мэдээлэл
		4.1.2.3 Шинэлэг ажил	Шинэлэг ажилд өгсөн ажлын хэсгийн үнэлгээний дундаж оноо	15			
		4.1.3. Илтгэлийн үнэлгээ	Илтгэл бэлтгэсэн байдал	5			
2	Дүн			75			
3	Нийт дүн			370			

СҮМЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН НЭГДСЭН
ҮНЭЛГЭЭ

Үзүүлэлт		Хувь	Оноо
1	2	3	4
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2. Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт		
Дундаж			
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Аймгийн Засаг даргаас сумдын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт 2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 3. Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт 4. Байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгжилт		
Дундаж			
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээ 2. Шилэн дансны хөтлөлт, ОНХС-ийн хэрэгжилт 3. Хөндлөнгийн үнэлгээ		
Дундаж			
Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт, онцлох ажлын үнэлгээ	1. Гэрээний үүргийн биелэлт, шинэлэг ажлын үнэлгээ		
Дундаж			
Ерөнхий үнэлгээ			

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС